



**ҮЙЛДВЭР,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2013/12

**Улаанбаатар хот
2014 он**



ГАРЧИГ

	Агуулга	Хуудасны дугаар
1.	Аж үйлдвэр	2
2.	Мал аж ахуй	8
3.	Ургац хураалт, өвс хадлан	12

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.



1.АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр, 2013 оны эцэст 2608.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос 336.2 тэрбум төг буюу 14.8 хувиар өслөө. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр, 2013 оны эцэст 7348.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1625.2 тэрбум төг буюу 28.4 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн оны үнээр, 2013 оны эцэст 6456.6 тэрбум төг болж, 3780.6 тэрбум төг буюу 58.6 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн эцэст, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011	2012	2013	$\frac{2013}{2012}$ %
Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн. 2005 оны зэрэгцүүлэх үнээр	2 058 961.3	2 272 055.3	2 608 299.0	114.8
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	628 083.7	744 068.5	794 435.6	106.8
Хүнсний бүтээгдэхүүн. ундаа үйлдвэрлэл	312 340.0	345 277.3	386 406.3	111.9
Тамхи үйлдвэрлэл	25 544.9	21 071.9	18 899.3	89.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	101 786.5	82 332.5	88 936.1	108.0
Хувцас үйлдвэрлэл. үслэг арьс боловсруулалт	14 655.4	7 473.9	10 285.9	137.6
Арьс шир боловсруулах. ширэн эдлэл. гутал үйлдвэрлэл	6 810.4	12 538.5	11 128.7	88.8
Мод. модон эдлэл үйлдвэрлэл	2 715.3	2 866.2	2 570.4	89.7
Цаас. цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 925.1	4 076.1	3 597.3	88.3



**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн,
дэд салбараар, оны үнээр, жил бүрийн эцэст, сая төг**

Аж үйлдвэрийн салбар	2011	2012	2013	Үүнээс: гадаадад
Аж үйлдвэр. бүгд	5626746.2	6058023.8	6456583.2	3780559.1
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	1566825.2	1949749.9	2106308.3	729574.9
Хүнсний бүтээгдэхүүн. ундаа үйлдвэрлэл	664 855.2	719 877.8	815 274.7	17 390.5
Тамхи үйлдвэрлэл	41 611.6	45 211.7	66 445.9	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	179 933.2	175 078.8	228 674.0	128 657.1
Хувцас үйлдвэрлэл. үслэг арьс боловсруулалт	15 614.8	20 604.6	33 601.5	5 384.9
Арьс шир боловсруулах. ширэн эдлэл. гутал үйлдвэрлэл	2 451.5	8 565.1	8 409.3	4 001.0
Мод. модон эдлэл үйлдвэрлэл	11 500.9	15 660.5	13 998.4	-
Цаас. цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 772.9	14 935.0	13 243.4	-

**Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт,
жил бүрийн эцэст**

Бүтээгдэхүүн	Хэм. нэгж	2011	2012	2013	$\frac{2013}{2012}$ %
Хивс	мян.м ²	850.8	915.8	852.9	93.1
Сүлжмэл эдлэл	мян.ш	759.2	795.6	932.9	117.3
Самнасан ноолуур	тн	874.3	417.0	521.8	125.1
Эсгий	мян.м	263.2	251.4	178.1	70.8
Тэмээний ноосон хөнжил	мян.м	25.8	8.2	14.7	179.3
Эсгий гутал	мян.хос	42.6	34.0	20.8	61.2
Нэхий дээл	ш	22 520	9 024	16 771	185.8
Савхин гутал. ботинк	мян.хос	9.1	18.3	26.5	144.5
Барилгын модон хаалга. цонх	м ²	13 583.3	7 573.2	12 412.3	163.9
Барилгын шалны банз	м ³	1 690.2	1 150.6	845.6	73.5
Зүсмэл материал	м ³	10 558.4	14 213.2	9 792.7	68.9
Дэвтэр	мян.ш	10 779.3	10 923.4	6 552.9	60.0
Ариун цэврийн цаас	мян.ш	3 328.5	5 278.4	5 479.8	103.8
Сонин	сая.х.д.х	40.8	69.2	55.9	80.8
Ном	сая.х.д.х	47.5	60.8	55.5	91.3

**Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
жил бүрийн эцэст**

Бүтээгдэхүүн	Хэм. нэгж	2011	2012	2013	$\frac{2013}{2012}$ %
Үхрийн мах	т	4 324.5	3 311.7	7 373.7	222.7
Хонины мах	т	4 498.7	4 721.3	6 416.6	135.9
Адууны мах	т	2 592.3	845.4	2 354.6	278.5
Ямааны мах	т	1 748.7	4 280.1	3 614.1	84.4
Гахайн мах	т	19.0	21.5	13.4	62.3
Өлөн гэдэс	мян.гогцоо	1 250.8	941.9	696.1	73.9
Хиамны зүйл	т	2 204.4	2 222.7	2 347.2	105.6
Шингэн сүү	мян.л	20 845.5	25 120.3	26 607.4	105.9
Тараг	мян.л	8 786.9	7 804.6	8 803.5	112.8
Цөцгий, цөцгийн тос	т	1 078.8	1 590.4	1 191.9	74.9
Аарц, бяслаг	т	70.4	329.9	140.7	42.6
Дээд гурил	т	21 605.6	32 747.8	34 981.3	106.8
Нэгдүгээр гурил	т	72 885.1	67 566.5	124 969.8	185.0
Хоёрдугаар гурил	т	10 761.2	14 584.5	28 158.5	193.1
Талх	т	23 882.0	25 448.5	25 047.5	98.4
Нарийн боов	т	13 027.5	13 880.8	18 747.4	135.1
Бялуу	т	610.4	826.5	860.9	104.2
Чихэр	т	79.4	92.7	44.6	48.1
Гоймон	т	2 239.0	3 191.7	1 531.9	48.0
Спирт	мян.л	3 440.4	3 305.3	1 925.4	58.3
Архи	мян.л	25 473.3	26 814.6	24 774.0	92.4
Дарс	мян.л	122.8	79.8	78.3	98.1
Шар айраг	мян.л	57 133.6	65 124.6	63 775.3	97.9
Цэвэр ус	мян.л	32 861.0	35 930.5	47 360.4	131.8
Амтат ус, ундаа	мян.л	75 842.3	74 552.4	78 918.3	105.9
Жүүс	мян.л	54 432.7	66 689.2	84 426.6	126.6



Экспортын гол нэрийн бараа, жил бүрийн эцсийн байдлаар

Гол нэр төрлийн бараа	Хэм. нэгж	2012		2013 *		$\frac{2013^*}{2012}$ %	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Адууны мах	т	1462.1	4765.3	2597.8	7573.0	177.7	158.9
Малын дайвар бүтээгдэхүүн	т	821.2	511.9	790.4	1320.9	96.2	2.6*
Үхэр, адууны боловсруулсан шир	сая дм ²	43.0	5339.1	43.1	5364.9	100.4	100.5
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая дм ²	182.5	16074.2	162.2	15316.8	88.9	95.3
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая дм ²	61.1	6549.5	92.1	9883.6	150.8	150.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	200.7	2162.1	350.2	4105.9	174.5	189.9
Хонины самнаагүй ноос	т	4494.3	5415.6	2388.4	3009.7	53.1	55.6
Бохир ноолуур	т	3597.8	145379.5	4077.9	188855.9	113.3	129.9
Самнасан ноолуур	т	532.9	47829.9	564.5	56081.2	105.9	117.3

Тайлбар: *- урдчилсан гүйцэтгэл
Х* -дахин их



Импортын гол нэрийн бараа, жил бүрийн эцсийн байдлаар


Гол нэр төрлийн бараа	Хэмжих нэгж	2012		2013*		2013* / 2012 %	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Өндөг	мян.ш	91983.0	7974.8	103003.0	10894.7	112.0	136.6
Төмс	т	3162.4	866.1	32.0	10.5	1.0	1.2
Сонгино, сармис	т	10477.1	1861.1	16241.1	2781.1	155.0	149.4
Алим, лийр	т	9745.0	2809.6	11501.2	4699.0	118.0	167.2
Ногоон цай	т	2033.6	1944.7	2298.2	2319.1	113.0	119.3
Цагаан будаа	т	31628.8	17209.3	20397.7	9452.7	64.5	54.9
Шар будаа	т	1279.9	505.4	2007.9	944.4	156.9	186.9
Гурил	мян.т	50.1	16620.2	23.9	10095.0	47.6	60.7
Ургамлын тос	т	5969.6	8419.1	5727.5	8226.0	95.9	97.7
Элсэн чихэр	т	44896.4	22958.5	44441.4	23563.2	99.0	102.6
Хатуу чихэр	т	6163.4	12028.9	5213.6	9741.2	84.6	81.0
Согтууруулах биш ундаа	мян.л	22714.0	20085.8	25388.5	23005.2	111.8	114.5
Согтууруулах ундаа	мян.л	32124.4	33366.5	35815.8	32190.7	111.5	96.5
Үүнээс: Шар айраг	мян.л	28674.5	18030.7	33208.0	18840.1	115.8	104.5
Янжуур	сая ш	2138.1	59295.6	1948.4	54686.7	91.1	92.2
Дүнсэн тамхи	т	226.8	970.3	245.6	1088.1	108.3	112.1
Автобензин	мян.т	389.1	474109.6	380.1	439648.4	97.7	92.7
Дизель түлш	мян.т	715.5	818790.0	772.9	880559.4	108.0	107.5

Тайлбар: *- урдчилсан гүйцэтгэл

2.МАЛ АЖ АХУЙ

Улсын хэмжээгээр 2013 оны эцэст 45.1 сая толгой мал, үүний дотор 2618.4 мян.адуу, 2908.5 мян.үхэр, 321.5 мян.тэмээ, 20060.3 мян.хонь, 19218.5 мян.ямаа тоологдов.

Малын тоо, төрлөөр



Малын нийт тоо өмнөх оныхоос 4.2 сая буюу 10.3 хувиар өссөний дотор адуу 288.1 мянга буюу 12.4 хувь, үхэр 323.9 мянга буюу 12.5 хувь, тэмээ 15.6 мянга буюу 5.1 хувь, хонь 1.9 сая буюу 10.6 хувь, ямаа 1.7 сая буюу 9.5 хувиар өсчээ.


Нийт мал сүрэгт хонь 44.5 хувь, ямаа 42.6 хувь, үхэр 6.4 хувь, адуу 5.8 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж, өмнөх оныхоос хонь, тэмээ, үхэр, адууны эзлэх хувь 0.1-0.2 пунктээр өсч, харин ямааных 0.3 пунктээр буурсан байна.

Малын тоо 2013 оны эцэст өмнөх оныхоос 15 аймаг, Улаанбаатар хотод 5 төрөл дээрээ өсчээ. Өвөрхангай (515.4 мянга), Архангай (369.1 мянга), Баянхонгор (346.2 мянга), Төв (328.3 мянга), Дундговь (324.3 мянга) аймгуудад малын тоо хамгийн өндөр өсөлттэй байна.

Архангай (3772.3 мянга), Хөвсгөл (3609.2 мянга), Төв (3573.0 мянга), Өвөрхангай (3486.0 мянга), Баянхонгор (2987.1 мянга) аймгууд 2013 онд хамгийн олон мал тоолуулж эхний таван байранд орсон байна.

Адуун сүргийн тоогоор Төв, Архангай, Булган, Өвөрхангай, Сүхбаатар аймаг; үхэр сүргийн тоогоор Архангай, Хөвсгөл, Төв, Булган, Хэнтий аймаг; тэмээн сүргийн тоогоор Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Дундговь аймаг; хонин сүргийн тоогоор Архангай, Төв, Хөвсгөл, Өвөрхангай, Булган аймаг; ямаан сүргийн тоогоор Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Хөвсгөл, Төв аймаг эхний таван байранд орсон байна.

Малын тоо, аймаг, нийслэлээр, 2013 оны байдлаар




Улсын хэмжээгээр 2013 оны эцэст малтай 209.8 мян.өрх байгаагийн 145.2 мян.өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй малчдын тоо 2013 оны эцэст 285.5 мянга болж, 16-34 насны малчид 38.5 хувь, 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчид 51.8 хувь, тэтгэврийн насны малчид 9.7 хувийг эзэлж байна.


Малтай өрхийн тоо өмнөх оныхоос 1.9 хувиар, үүнээс 500 хүртэлх малтай өрхийн тоо 4.0 хувиар буурч, харин 500-аас дээш малтай өрхийн тоо 28.0 хувиар өссөн байна.

Улсын хэмжээгээр 2013 онд малтай нэг өрхөд ногдох малын тоо дунджаар 213 болж, өмнөх оныхоос 14.9 хувиар өслөө. Малтай нэг өрхөд 14 адуу, 12 үхэр, 2 тэмээ, 95 хонь, 91 ямаа ногдож байна. Өмнөх оныхоос малтай нэг өрхөд ногдох тэмээ 1, адуу 3, ямаа 7, хонь 8-аар өсч, харин үхрийн тоо өөрчлөгдөөгүй байна.


Малтай өрхийн тоо, малын тооны бүлэглэлтээр



Малчин өрхийн тоо



Нэг малчин болон малтай өрхөд ногдох мал



Малтай өрхийн 41.8 хувь нь 100 хүртэл, 22.4 хувь нь 101-200, 25.3 хувь нь 201-500, 8.2 хувь нь 501-999, 2.3 хувь нь 1000-аас дээш тооны малтай байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Төв, Сүхбаатар, Булган, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий аймагт улсын дунджаас 6-104 толгойгоор илүү, бусад аймагт 1-147 толгойгоор бага байна.


Малчин нэг өрхөд ногдох малын тоо 2013 оны эцэст дунджаар 271 болж, өмнөх оныхоос 11.1 хувиар өслөө. Нийт малчин өрхийн 41.3 хувь нь Хангайн, 25.9 хувь нь Баруун, 20.4 хувь нь Төвийн, 11.4 хувь нь Зүүн бүсэд, 1.0 хувь нь Улаанбаатарт байна.

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар оны эхний эх малын 88.4 хувь буюу 15.7 сая эх мал төллөжээ. Гүүний 82.0 хувь, үнээний 83.2 хувь, ингэний 48.3 хувь, эм хонины 90.5 хувь, эм ямааны 88.0 хувь нь төллөв. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 0.8 пунктээр өссөнөөс гүүнийх 4.1, үнээнийх 3.0, эм ямааных 1.5 пунктээр дээгүүр, харин ингэнийх 7.6 пунктээр, эм хониных 0.4 пунктээр доогуур байна.

Нийт гарсан төлийн 15.2 сая буюу 96.3 хувийг нь 2013 онд бойжуулсан нь өмнөх оныхоос 1.8 сая толгойгоор өсч, төл бойжилтын хувь 0.2 пунктээр доогуур байна.

Унаганы 95.8 хувь, тугалны 97.1 хувь, ботгоны 97.0 хувь, хурганы 96.9 хувь, ишигний 95.6 хувь нь бойжиж, төл бойжилтын хувь хурга, ишиг, ботгоных 0.1-0.6 пунктээр буурч, тугал болон унага бойжилт 0.2-0.4 пунктээр дээгүүр байна.


Бойжсон төл



Оны эхэнд тоологдсон нийт малын 1.9 хувь буюу 792.5 мянган том мал 2013 онд зүй бусаар хорогдов.

Нийт хорогдсон малын 94.0 мян буюу 11.9 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Оны эхний малд хорогдлын эзлэх хувь Хангайн бүсэд хамгийн их буюу 2.8, Зүүн бүсэд 1.7, Баруун бүсэд 1.7, Улаанбаатар хотод 1.2, Төвийн бүсэд 0.8 байна.

Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2013 онд 66 болж, өмнөх оныхоос 10.0 хувиар өслөө. Энэ үзүүлэлт Орхон аймагт 855, Улаанбаатар хотод 353, Дархан-Уул аймагт 290, Булган аймагт 198, Архангай аймагт 195, Сэлэнгэ 146, Хөвсгөл аймагт 137 толгой байгаа нь улсын дунджаас 70.5-788.9 толгойгоор илүү байна.




3. УРГАЦ ХУРААЛТ, ӨВС ХАДЛАН

Улсын хэмжээгээр 2013 онд нийт 415.4 мян.га талбайд тариалалт хийснээс 293.3 мян.га-д үр тариа, 15.5 мян.га-д төмс, 8.3 мян.га-д хүнсний ногоо, 14.4 мян.га-д тэжээлийн ургамал, 83.9 мян.га-д техникийн ургамал тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 35.7 мян.га буюу 9.4 хувиар нэмэгдсэн байна.

Үр тариа 387.0 мян.т, төмс 191.6 мян.т, хүнсний ногоо 101.8 мян.т-ыг 2013 онд хураан авч, 1169.3 мян.т хадлан, 36.6 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос хүнсний ногоо 2.8 мян.т буюу 2.9 хувиар нэмэгдэж, гар тэжээл 2.5 мян.т буюу 6.5 хувь, хадлан 5.8 мян.т буюу 0.5 хувь, төмс 54.3 мян.т буюу 22.1 хувь, үр тариа 92.3 мян.т буюу 19.3 хувиар буурсан байна.

Га тутмаас 13.2 цн үр тариа, 123.6 цн төмс хураасан нь өмнөх оныхоос үр тариа 2.5 цн буюу 15.7 хувь, төмс 22.6 цн буюу 15.5 хувиар доогуур байна. Үр тарианы га-гийн ургац Сэлэнгэ, Булган, Ховд, Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Орхон, Баян-Өлгий аймагт улсын дунджаас 0.3-15.0 центнерээр өндөр, харин бусад аймагт 0.2-5.2 центнерээр доогуур байна.


Хураасан үр тариа, мян.т
жил бүрийн эцэст



Төмсний га-гийн ургац Ховд, Төв, Хэнтий, Сэлэнгэ аймагт улсын дунджаас 4.6-15.8 центнерээр өндөр, харин нийслэл болон бусад аймагт 2.5-90.9 центнерээр доогуур байна.

Хураасан үр тарианы 48.3 хувь нь Сэлэнгэ, 20.9 хувь нь Төв, 10.5 хувь нь Булган, 6.3 хувь нь Хөвсгөл; төмсний 35.8 хувь нь Төв, 29.2 хувь нь Сэлэнгэ, 5.9 хувь нь Ховд, Дархан-Уул, Булган аймагт тус бүр 4.4 хувь нь ногдож байна.

Хураасан төмс, хүнсний ногоо, мян.т
жил бүрийн эцэст




Бүсээр авч үзэхэд хураасан үр тарианы 72.3 хувь нь Төвийн, 18.5 хувь нь Хангайн, 6.2 хувь нь Зүүн, 3.0 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы хэмжээ өмнөх оныхоос Баруун бүсэд 0.8 мян.т буюу 7.9 хувиар өсч, Зүүн бүсэд 4.5 мян.т буюу 15.6 хувь, Хангайн бүсэд 6.9 мян.т буюу 8.8 хувь, Төвийн бүсэд 81.8 мян.т буюу 22.6 хувиар буурлаа.

Хураасан нийт хүнсний ногооны 34.9 хувь нь Сэлэнгэ аймагт, 15.0 хувь нь Дархан-Уул аймагт, 13.4 хувь нь Ховд аймагт, 9.9 хувь нь Төв аймагт, 26.8 хувь нь нийслэл болон бусад аймагт ногдож байна.

Бэлтгэсэн нийт хадлангийн 200.4 мян.т буюу 17.1 хувь нь Хөвсгөл, 164.5 мян.т буюу 14.1 хувь нь Сэлэнгэ, 128,6 мян.т буюу 11.0 хувь нь Хэнтий, 107,8 мян.т буюу 9.2 хувь нь Төв, 96.9 мян.т буюу 8.3 хувь нь Булган, 75.4 мян.т буюу 6.4 хувь нь Архангай, 61.4 мян.т буюу 5.2 хувь нь Баян-Өлгий аймаг, 60.8 мян.т буюу 5.1 хувь нь Дархан-Уул аймагт, үлдсэн 273.5 мян.т буюу 23.5 хувь нь нийслэл болон бусад аймагт ногдож байна.

Бэлтгэсэн хадлан, мян.т
жил бүрийн эцэст



----- ооОоо -----